

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. /Даалгавар бүр 2 оноотой/

Морь

/өгүүллэгийн хэсгээс/

...Өвгөн дархи модны нөмөрт хээр морь омруугаа бараг газарт шаах шахам бөгтийж цавиных нь хөх мах чичирнэ. Нүднээс нь нуух цувж, ташаан толгойн яс нь арай л арьсыг нь цоолж гарч ирээгүй бололтой. Сүүлийг нь бүр угаар нь тастжээ. Төвөд, Тангууд гуяных нь махнаас өм огтолсныг Чойнзон элдэв арга хэрэглэж эдгээсэн удаатай.

“Аав нь үнэндээ энэ нутагт амьдарч чадахгүй юм байна. Уулзах ерөөл тавилан байх болов уу? Чамд сарвайх юм алга. Морио л үлдээе. Унаж гийгүүлэхгүй ч монгол шивтэр элгийг чинь дэвтээх биз. Харин үхэхэд нь тасын хоол болгочхолгүй толгойг нь өндөр газар тахиарай” гэж захиж үлдээгээд Ар монгол руугаа буцахад Чойнзон хувилгаан шороо самардан уйлж хоцорчээ. Хэчнээн хоног уйлснаа ч мэддэггүй. Дунгийн нэг хэвийн дуунаар гадаалахдаа өглөө бүр мориныхоо магнайг үнэрлэхэд агь ганга, айраг цагаа, аавынх нь үнэр ханхлах шиг болоход “Эдэнд нулимсаа үзүүлэхгүй юм шүү” гэж жанчаараа толгойгоо нөмрөөд гол дуганы шулуун шатаар өгсдөг байсан аж.

/До. Цэнджав/

Үгийн тайлбар: дархи-унанги том мод

дуган-шашны зан үйл үйлдэх байр

жанч-лам нарын нөмрөх хуниас гаргаж хийсэн хувцас

1. Аав нь хүүгээ хүний нутагт орхихдоо юу үлдээсэн бэ?
 А.Агь ганга, айраг цагаа
 В.Нутгийн шороо
 С.Хээр морь
 D.Дуут дун
 E.Ээжийнх нь оёж өгсөн даалин
2. Чойнзон хувилгаан өглөө бүр жанчаараа толгойгоо нөмөрдгийн учир юу байв?
 А.Их багшаасаа айдаг учраас
 В.Яс арьс болсон морио харахгүй байя гэж шийдсэн учраас
 С.Дунгийн нэг хэвийн дууг сонсохгүй байя гэсэнээс
 D.Судар номоо цээжилдэг арга нь нарийн учраас
 E.Хүний газар муугаа үзүүлэхгүй гэсэн учраас
3. Уг үйл нь үнэн бодитой болоход бүрэн итгэсэн баймж утгатай өгүүллэрийг олоорой.
 А.Арай л арьсыг нь цоолж гарч ирээгүй бололтой
 В.Үнэндээ энэ нутагт амьдарч чадахгүй юм байна
 С.Хэчнээн хоног уйлснаа ч мэддэггүй
 D.Уулзах ерөөл тавилан байх болов уу
 E.Омруугаа бараг газарт шаах шахам бөгтийжээ
4. Чойнзонызан байдлынонцлогт тохирсон хэлцийг сонгоно уу.
 А.Хал үзэж, халуун чулуу долоох
 В.Эгэмнээс нь татаж, эрийн цээнд хүргэх
 С.Харцаганд ээрэгдсэн болжмор шиг
 D.Хэрээ мянган жил болсон ч хар хэвээрээ
 E.Мордсоны хойно таваг тавих
5. Эхийн өнгө аясыг зөв тодорхойлсныг олоорой.
 А.Нүднээс гартал турж, зовон тарчилж буй морийгголлон өгүүлж буй тул харууслын өнгө аястай
 В.Хүний нутагтбайгааморины зовлон, аав ээж, нутаг усаа санасан хүний тухай илэрхийлсэнтүл таагүйөнгө аястай
 С.Аав нь хүний нутагт хүүгээганц морьтой орхиод явж байгаатул гэмшил өнгө аястай
 D.Төвөд, Тангуудууд морины гуяных нь махнаас өм огтолсныг бодоход зэвүүцсэн өнгө аястай
 E. Хүний газар Чойнзон муугаа үзүүлэхгүйг хичээж байгаа учраас сэрэмжилсэн өнгө аястай

6. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг олоорой.
 А.Морины турсан шалтгааныг тайлбарлаж, Чойнзоны хийсэн үйлүүдийг дэс дараалан өгүүлсэнтүл тайлбарламж, хүүрнэмж хосолсон хэв маяг
 В.Чойнзон хувилгааны амьдралыг цагийн дарааллын дагуу зураглан дүрсэлсэнтүл хүүрнэмж
 С.Чойнзон хувилгааны эх нутгаа санагалзахын учир начрыг баталсан тул эргэцүүлэмж
 D.Морины шинж байдлыг зурагласан тул тоочимж
 E. Эцэг нь хүүдээ морио үлдээсэн шалтгааныг тайлбарласан тул тайлбарламж
7. Эхийн гол санаанд тохирох хэлцийг олоорой.
 А.Бандийн санаа ширээнд, бахын санаа далайд
 В.Удам сайтын унага, угсаа сайтын үр
 С.Хүлгийн сайныг бачим цагт, хүний сайныг гачиг цагт
 D.Дэм дэмэндээ, дээс эрчиндээ
 E.Аавын бийд хүнтэй танилц, агтны бийд газар үз
8. “Морио л үлдээе. Унаж гийгүүлэхгүй ч монгол шивтэр элгийг чинь дэвтээх биз. **Харин** үхэхэд нь тасын хоол болгочхолгүй толгойг нь өндөр газар тахиарай” гэсэн өгүүлбэрийн онцолсон хэсгийн утгад тохирохыг нь олоорой.
 А. эсрэгцүүлсэн В. лавшруулсан С.зэрэгцүүлсэн
 D.харьцуулсан E.ойролцоо болгосон
9. “Хээр морь омруугаа бараг газарт **шаах** шахам бөгтийж цавиных нь хөх мах чичирнэ” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг солин найруулбал аль нь оновчтой байх вэ?
 А.үнэрлэх В.хаях С.цохих D. шүргэх E. наах
10. “**Нүднээс нь нуух цувж, ташаан толгойн яс нь арай л арьсыг нь цоолж** гарч ирээгүй бололтой” гэсэн өгүүлбэрийн онцолсон хэсгийн дүрслэлтэй ёгтолсон утгаараа дүйхийгнь олоорой.
 А.Ундаассанхан морийг усан дээрээ тавина, усан хар нүдийг ээж дээрээ тавина...
 В. Ташаан толгой нь тэвхийж, хавирганы яс нь зурагсан...
 С.Нүдний ухархайд нь шувуу өндөглөмөөр, ташаан толгойд нь хувин өлгөмөөр...
 D.Тууш нуруу нь халцарч, дөрвөн туурай нь эмтрээд, туг сүүл нь ширэлдсэн...
 E.–Ээжээ, ээжээ дөмөр дөмөр алхдаг дөрвөн хөл чинь юунд гуйвга гуйвга гээд байна аа?
11. “Нүднээс нь нуух цувж, ташаан толгойн яс нь арай л арьсыг нь цоолоогүй бололтой”- өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
 А.Холимог нийлмэл өгүүлбэр
 В.Угсарсан нийлмэл өгүүлбэр
 С. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
 D. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр
 E.Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
12. “Арай ч дээ, гуянаас нь өм огтолчхож...” гэсэн өгүүлбэрт тохирох загварыг олоорой.
 А.Мэдрэх өгүүлбэр+энгийн өгүүлбэр
 В.Зөвших өгүүлбэр+энгийн өгүүлбэр
 С.Хандах өгүүлбэр+энгийн өгүүлбэр
 D.Илэрхийлэх өгүүлбэр+энгийн өгүүлбэр
 E. Энгийн өгүүлбэр+энгийн өгүүлбэр
13. Цөм бус бүтэцтэй өгүүлбэрийг олоорой.
 А.Чойнзон шороо самардана В.Шивтэр элгийг чинь дэвтээнэ
 С.Үнэр ханхална D.Морио л үлдээе
 E.Газар тахиарай

14. Эхийн өгүүлбэрүүдээс салааланхувиргасныг олоорой.
 А.Морио л чамтай хамт үлдээе
 В.Чамд өгөх юм алга
 С.Чулуун шатаар өгсөхдөө жанчаараа толгойгоо нөмрөөд...
 D.Хээр морь бөгтийнө
 E.Чойнзон уйлж хоцорчээ
15. Эхийн өгүүлбэрүүдээс найруулгын дээд зэрэгт хувиргасныг олоорой.
 А.“Эдэнд нулимсаа үзүүлэхгүй юм шүү” гэж хувцсаараа толгойгоо нөмөрнө
 В.Уулзахын учрал байх болов уу
 С.Харин шороодоход нь тасын хоол бүү болгоорой
 D.Хэчнээн хоног гонгиносноо ч мэддэггүй
 E. Монгол молор элгийг чинь дэвтээх биз
16. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонгоно уу.
 агь ганга, аавынх нь үнэр, айраг цагаа, цавиных нь мах,.....
 А.өглөө бүр В.өндөр газарС.ерөөл тавилан
 D.морины омруу E.нутгийншороо
17. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай үгийг олоорой.
 А.нутгийншороо В.өндөр газар С.гол дуган D.дархи мод E. агь ганга
18. “Монгол шивтэр элгийг чинь дэвтээх биз” гэсэн өгүүлбэрийн утгыг олоорой.
 А.Харж хандаж, хамгаалж байх хөрөнгөтэй
 В.Эх нутаг юугаа санагалзахад хань болж тайвшруулах юмтай
 С.Эцэг нь шидийн аргаар эх нутаг, ээж аавын үнэрийг моринд шингээсэн
 D.Морио сайн харж хандаж бай, эрдмээ сураад буцахад чинь унаа болог
 E.Морины шивтэр үнэрлэвэл элэгний чинь өвчинд сайн
19. “...Энэ нутагт амьдарч чадахгүй юм байна” гэсэн өгүүлбэрийн онцолсон үг ямар газар орныг төлөөлсөн бэ?
 А. Ар МонголВ.Хятад С. Төвөд, Тангууд D.Энэтхэг E. Өвөр Монгол
20. Төрөл биш утгатай үгийг олоорой.
 А.цоолВ.цоолборС.цооч D.цоохор E.цоорхой
21. Эхээс сонгосон үгсээс үгийн бүтцээр буруу задалсныг нь олоорой.
 А. тас+т+0+0+жээ В.бөгт+ий+0+0+ж С.амьд+р+0+0+ч
 D.хэрэг+л+0+0+ж E.гад+аа+л+0+0+х+д+аа
22. “Чойнзон элдэв арга хэрэглэж эдгээсэн удаатай” гэсэн өгүүлбэрийн шууд тусагдахуун гишүүнийг олоорой.
 А. Чойнзон В.арга С.элдэв D.хэрэглэж E.эдгээсэн
23. Найрах аргаар холбогдсон холбоо үгийг зөв бүлэглэсэн хэсгийг сонгоорой.
 А. яс арьс, агь ганга, ерөөл тавилан В. дархи мод, өндөр газар, гол дуган
 С.морины омруу, нуух цувах, гол дуган D.нутгийншороо, морины омруу, арьс цоолох
 E. мах чичрэх, өндөр газар, угаар нь тастах
24. “Нүднээс нь нуух цувж...” гэсэн өгүүлбэр дэхгарахын тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?
 А.нэг нь нөгөөгийн үүслийн В.салж холдох С.тоо чанараар хязгаарлах
 D.үйлийн орны E.зорил хүслийн
25. “Малын өвчүү орчны газар” гэсэн тайлбарт тохирохыг нь олоорой.
 А.хөх мах В.цавьС.арьсD.ташааны ясE.омруу

26. “Морио л үлдээ” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой.
 А.ялгандуудах В.магадлан онцлох С.батлан онцлох
 D.зэрэгцүүлэн онцлох E.салган онцлох
27. “Ташаан толгойн яс нь арай л арьсыг нь цоолж гарчирээгүй бололтой” гэсэн өгүүлбэрээр илрэх баймж утгыг зөв тодорхойлсныг олоорой.
 А.өөрийн үзлийг илтгэх В.бүрэн итгэсэн С.таамаглах
 D.ерөнхийлөн тодруулах E. санамсаргүй тохиол
28. “Жанчаараа толгойгоо нөмрөөд гол дуганы шулуун шатаар өгсдөг байсан аж” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ?
 А. -снөө В.-нгөө С.-хлөөр D. -нгүүт E.-н
29. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
 А.уржигдар, өндөр, үдэш, урд, цаана
 В.маргааш, өндөг, орой, урьд, цаашаа
 С.өнөөдөр, өнхөр, үдэд, сая, наашаа
 D. нөгөөдөр, өмнө, өглөө, урд,наана
 E.өчигдөр, өндөр, шөнө, хожим, дээр
30. Цэгийн оронд зөв бичгийн дүрмийн алдаагүй үгийг нөхөөрэй.
 Тэд явсаар оройхон
- А.буудалаллаа В.буудалалаа С.буудаллалаа
 D.буудаллаа E.буудалаа
31. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
 А. Цэгцэрийн шар тал нэртэй их хөндийн дундуур би цагаан цавьдар мориороо хатируулан буцаж явлаа.
 В.Тэнгэрийн тэртээд зурвас цахилгаан гялсхийн, үе үе орчныг гэрэлтүүлнэ.
 С. Байгалийн сайханд зугаалан, бас ч үгүй байгалийн зураг дарж, байгалиа цэвэрлэхийн төлөө сэтгэл өвөрлөсөн билээ.
 D.Бараан үүлс юу юугүй хуралдаж, ойр зуурын армаг тармаг мод исгэрэн шуугина.
 E. Бөртэ охинтой учруулж, ураг удмыг гийгүүлэх жаргалын нарыг мандуулаад гэртээ буцаж явсан юм сан.
32. Монголын нууц товчоо зохиолд:Оюунтайтөрсөн Өэлүнэх үр хүүхдээхэрхэн өсгөсөнтухайөгүүлсэн мөрүүдийн орхигдсон хэсгийг сонгоннөхөөрэй.
 Оёдолтдээлийгогшуулан
 Оготорхормойгшуун
 Ононмөрнийг өгсөж
 Олирсмойлыг түүж
 Өчүүхэнхөвүүдээхайрлан тэжээж
 Өдөр шөнийг аргацаан өнгөрүүлэв.
- А. бүсэлж, өмсч, мацаж, хурааж
 В. шууж, бүсэлж, давж, өгч
 С. шууж, ороож, алхаж, хурааж
 D. нөмөрч, хавчуулж, гүйж, авчирч
 E. өмсч, бүсэлж, уруудаж, явж
33. Монголын нууц товчоо зохиолдТаргудай-Хирилтуг:
 - Хурганы үс гуужив, төлөгнийбиетөлживгэсэннь ямарутгатайвэ?
 А. Хаварцагирсэн
 В. Өэлүнийхөвгүүд томболов
 С. Хурганы үс гуужижунасан, төлөгнийбиетөлжижтэнхээрсон
 D. Улсоронхурганы үс мэтбутарч байгаа
 E. Хурга төлгийг өсгөх хэрэгтэй

34. "...Хив бүстэй хилэн оймстой, гунан халтар морьтой хөвүүн:
-Таныг сурж ир гэсэн биш, барьж ир гэсэн биш үү. Үгийг ахмадад нь хэлдэг, дээлийг захаар нь өмсдөг биш үү. Амьд хүргэгтүн намайг, амаараа хүрч мэдүүлье гэв"—ямар зохиолын дүрслэлт хэсэг вэ?
А. "Убаши хунтайжийн тууж" МСУЗ
В. "Үрэгдсэнийг хүлээгч" өгүүллэг /Д.Нам/
С. "Халуун амьсгал" тууж /Д.Г/
D. "Хув Нагваралын тууж" МСУЗ
E. "Нууцыг задруулсан захиа" өгүүллэг /Б.Р/
35. Б.Лхагвасүрэн "Үр могой" найраглалын хэсгүүдээс байгаль хүртэл гай зовлонтой үр мэндлэхийг зөгнөж ёрлоод байгааг илэрхийлсэн хэсгийг олоорой.
А.Нар бүлэгнэн мандахаас өмнө, гал дүлэгнэн мандахас өмнө...
В. Сул асгарах халуун цусны тунараанд, сүвэгч нь сохор тэвнэ шиг толгойгоо дүрнэ...
С.Газардахын аранга тойрно, ганцаардлын айдас тойрно...
D.Цаашаа наашаа холхих хөлөнд цас ёолно, цалалзах жаврын үзүүрт хад улина...
E.Зэгэл үдэш шөнөтэй залгах, зөнөсөн нохой хий боргох...

36. Жангарын туужид:
"Ирсэн ерэн есөн жилийн юмыг
Тоочиж хэлдэг
Ирээгүй ерэн есөн жилийн юмыг
Тааж мэддэг...
Ямар их бэрх заргач ирэвч
Төдөлгүй хагалаад
Хар олбог дээр суудаг" нь хэн бэ?
А.Догшин хар Санал
B.Хүнд гарт Савар
C.Арслангийн Араг Улаан-хонгор
D.Баян Хүнхээн Алтан Цээж
E.Орчлонгийн сайхан Миньяан

37. Монгол бичгийн эхийг уншаад зөв хөрвүүлснийг олоорой.
А. Тогоо дүүрэх сөнтэй болог
Торх дүүрэх өрөмтэй болог
B.Тогоо дүүрэн сүүтэй болог
Торх дүүрэн өрөмтэй болог
C.Тогоо дүүрэн сөнтэй болог
Торх дүүрэн өрөмтэй болог
D.Тогоо дүүрэх сүүтэй булаг
Торх дүүрэх өрөмтэй булаг
E.Тогоо дүүрэн сүүтэй булаг
Торх дүүрэн өрөмтэй булаг



38. "данх/цайны/" гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэнийг нь олоорой.
A. B. C. D. E.

39. Тийн ялгалын нөхцөлийг буруу дагуулсан хэсгийг олоорой.
A. B. C. D. E.

40. Холбох эгшгийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой.
A. B. C. D. E.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлцийг үтгатай нь зөв харгалзуулаарай.


- | | |
|------------------|-------------------|
| a. Нүд чичлэх | 1. маш ширүүн |
| b. Нүдэнд хүйтэн | 2. үзэн ядах |
| c. Нүд хорсох | 3. аятайхан биш |
| d. Нүд бүлтийх | 4. зэмлэх, загнах |
| e. Нүүр нүдгүй | 5. гайхах |

2.2. Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--|------------------------|
| a. Хандгай буга харвах хүүтэй бол
Халиу булга эсгэх хүүхэнтэй бол | 1. Бэлгэ дэмбэрлийн үг |
| b. Эх нь энгэр дагана
Хүү нь хүн дагана | 2. Зүйр цэцэн үг |
| c. Эр чадлыг гайхуулагч
Эрхийн эрдмийг шалгагч... | 3. Ерөөл |
| d. Эр хүний хэрэглэдэг зүйлсээс
Цаас цавуу, бал бэх, бийр янтай... | 4. Магтаал |
| e. Ээжээрээ заалгах нь охины ёс
Эцгээ залгамжлах нь хүүгийн журамёс | 5. Онъсого |

2.3. Зурагт зааснаар нэртэй нь зөв харгалзуулаарай.

- a. хөмөлдрөг
- b. гөлөм
- c. хавтас
- d. олонцог
- e. ганзага



2.4. Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3	4
a	Ялгах эгшиггүйг	болно	хурга	гагна	хүргэ
b	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд уртэгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийггээхгүйг	Арав+аас	Дондог+ийг	Будаг+аар	Хөвөр+өөд
c	Зөөлний тэмдэг "и" болох үг	тахь+даг	шаагь+ж	хорь+сон	соль+чих
d	Эгшигт гийгүүлэгч эгшиггүй бичигдэх үг	өгүүл+л	нум+л	совин+ г	дугуйл+н
e	Эр үгэнд "ий"-г бичих үг	намар	уурга	тооно	тоног